



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 14 өдөр

Дугаар 1105

Шивээговь сум

Усан хангамжийн системийг алсын горимд оруулах ажлын гүйцэтгэлийг хүлээж авах комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1, 59.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”, Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.12 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Сумын 2021 оны “Орон нутгийн хөгжлийн сан”-ийн хөрөнгөөр хэрэгжих “Усан хангамжийн системийг алсын горимд оруулах” ажлыг хүлээн авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Комиссын дарга:

Ч.Сугармаа

(Засаг даргын орлогч)

Гишүүд:

О.Отгонбаяр

(Байгаль хамгаалагч)

Д.Алтанцэцэг

(Илчлэг Шивээ Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын инженер)

Ц.Адъяа

(1 дүгээр багийн иргэн)

Нарийн бичгийн дарга:

Ц.Замбага

(Хөрөнгө оруулалт, эдийн засаг)

421229029

төлөвлөлт, худалдаа авах
ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

2.Усан хангамжийн системийг алсын горимд оруулах ажилд хийгдсэн засварыг хөрөнгөнд бүртгэж, ашиглалт хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг Илчлэг Шивээ Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын захирал (Ш.Чинболд)-д үүрэг болгосугай.

3.Гүйцэтгэлийн ажлыг захиалагчаас гаргасан ажлын даалгаврын дагуу шаардлагад нийцсэн техникийн үзүүлэлтэд акт үйлдэн холбогдох баримтыг хавсарган хүлээлцэхийг комиссын дарга (Ч.Сугармаа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА *Ламия* П.ГАНЧИМЭГ

